



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/263

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэхь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 10 дугаар тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, 2022 оны "Аймгийн 2023 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй "Хантайшир уулын аймгийн 100 жилийн ой"-н хүрээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудыг сурталчилах, контент бэлтгэх ажлуудыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Гэрээний зардалд шаардагдах 16,000,000 (арван зургаан сая) төгрөгийг "Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ой, тохижилт болон бусад зардал"-ын батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР